

ОНОШИЛГОО, ХЭМЖИЛ ЗҮЙН ЛАБОРАТОРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОВЧ ТАЙЛАН

2021 оны 09 дүгээр сарын 17

Улаанбаатар хот

ИНЕГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2021 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр баталсан ИНҮТ-ийн харьяа Оношилгоо, хэмжил зүйн лабораторийн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай 18/21 дүгээр удирдамжийн хүрээнд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын ДАА-ны аудитор А.Мөнх-Эрдэнэ, санхүүгийн хяналтын мэргэжилтэн Ц.Оюут, Ж.Энэрэл нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2021 оны 09 дүгээр сарын 06-ны өдрөөс 2021 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийг дуустал хугацаанд дотоод аудит, хяналт шалгалтын ажлыг хугацаанд нь гүйцэтгэсэн.

ИНЕГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн баталсан удирдамжийн хүрээнд Оношилгоо, хэмжил зүйн лабораторийн 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацааны үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журам болон дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, цалин хөлсний бүртгэл тооцоо зэргийг үндсэн баримт нотолгоонд тулгуурлан шалгах, зарим эргэлзээтэй зүйлүүд дээр холбогдох албан тушаалтнаас тайлбар, тодруулга авч ажиллалаа.

Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын 4.7.-д заасны дагуу ИНҮТ нь тус лабораторийн 2021 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хянаж хагас жилээр үнэлэж дүгнэлт, зөвлөмж хүргүүлээгүй байна.

2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө боловсруулахдаа Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-д заасны дагуу боловсруулаагүй, тухайн онд хийж гүйцэтгэх ажлуудыг өмнөх онд хийж гүйцэтгэсэн ижил төрлийн ажлуудтай харьцуулахад харьцангуй багаар зорилтот түвшинг тодорхойлсон.

ОХЗЛ-ийн эрхлэгч, лаборант-бичиг хэрэг, аюулгүй ажиллагааны инженер, химич инженерийн албан тушаалын тодорхойлолтын албан тушаалд тавигдах тусгай шаардлагууд болох мэргэжил, мэргэшлийн шаардлагыг алдаатай боловсруулсан.

ХАБЭА-н орон тооны бус зөвлөлийн ажилтнууд ИНЕГ-ын даргын 2019 оны А/688 дугаар тушаалаар баталсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр үзлэг, гурван шатны хяналтыг зохион байгуулах журам”-ын дагуу нэг, хоёр, гурав дахь шатны хяналтыг хангалттай хэрэгжүүлж ажиллаагүй.

2020 оны Дотоод аудитын төлөвлөгөөг боловсруулахдаа аудитын шалгалтыг гүйцэтгэх багийн гишүүдээр сорилтын ахлах инженер, хэмжил зүйн ахлах инженер нарыг томилсон нь хараат бус байдлыг хангахгүй байна.

Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-д заасны дагуу дотоод хяналт, шалгалт гүйцэтгэхдээ эрх бүхий албан тушаалтнаар удирдамж батлуулаагүй, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах талаар хангалттай ажил хийгдэхгүй байна.

ОХЗЛ-оос өгсөн хүсэлт, тайлбарт дурдсаны дагуу лабораторын байрыг зориулалтын бус байранд нүүлгэсэн тохиолдолд Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн дагуу стандартын шаардлагыг ханган олгогдсон MNS ISO/IEC 17025:2018 “Хэмжил зүйн шалгалт тохируулга, механик хэмжилт болон сорилтын төрлөөр газрын тосны бүтээгдэхүүнд чанарын иж бүрэн шинжилгээ, үл эвдэх

сорил” итгэмжлэл цуцлагдах болон агаарын хөлгийн түлш, тос, тусгай шингэний чанарын иж бүрэн шинжилгээ хийх, хэмжих хэрэгслийн шалгалт, тохируулга зэрэг ажлуудыг гүйцэтгэх эрхгүй болох эрсдэлтэй байна.

Аудитын шалтгалтын үр дүнд гарсан алдаа, дутагдлыг арилгах, залруулах талаар Иргэний нисэхийн үндэсний төвд 1, тус лабораторид 7 зөвлөмж өгсөн болно.

ДОТООД АУДИТЫН АЛБА